




ЖИЛИЙН ТАЙЛАН 2015

Хүчтэй. Хамтдаа.



ЖИЛИЙН ТАЙЛАН 2015



Агуулга

<u>6 - 7</u> АЛСЫН ХАРАА		<u>28 - 29</u> ББСБ-ЫН ЗАХ ЗЭЭЛ
	<u>12 - 21</u> КОМПАНИЙН ТУХАЙ	
<u>8 - 9</u> ТУЗ-ИЙН ДАРГЫН ИЛГЭЭЛТ		<u>30 - 34</u> АУДИТЫН ТАЙЛАН
	<u>22 - 25</u> САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
<u>10 - 11</u> ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ		<u>35</u> ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД
	<u>26 - 27</u> ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН	



Алсын хараа

Ард Кредит нь санхүүгийн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэн зах зээлд манлайлж ажиллана.

Эрхэм зорилго

Бид Монгол Улсад банкны үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, санхүүгийн боловсролыг дэлгэрүүлэх зорилго бүхий нийгмийн хариуцлагын тэргүүлэгч байгууллага болно.

Үнэт зүйлс

Сэтгэл ханамжтай ажиллагсад
Харилцагч төвтэй, шинэлэг үйлчилгээ
Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа
Нийгмийн хариуцлага
Тогтвортой өндөр өгөөж



Чулуун ГАНХУЯГ
ТУЗ-ийн дарга

ТУЗ-ийн даргын ИЛГЭЭЛТ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, түншүүд, харилцагчид та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Ард Санхүүгийн Нэгдэл (АН) нэрийн дор нэгдсэн хамт олны хувьд өмнө нь төлөвлөж байсан олон ажлаа дүгнэж, шинэ эхлэлийг тавьсан сайхан он жил өнгөрлөө.

Ард Санхүүгийн Нэгдэл нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар өөрийн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм. Манай бүрэлдэхүүнд Ард Даатгал, Ард Кредит, Ард Секюритиз, Ард Актив, Ард Менежмент болон Хөрөнгө Оруулалтын Итгэлцлийн Сан (EIT) зэрэг компаниуд багтаж байна. EIT хөрөнгө оруулалтын сангаас Техник Технологийн Дээд Сургууль, Номын Хишиг, Уайлд Дижитал Эйжэнси, ТэнГэр Системс зэрэг санхүүгийн бус үйл ажиллагаа явуулдаг компаниудад хөрөнгө оруулалт хийн удирдлагад нь идэвхтэй оролцож, харилцан ашигтай хамтын ажиллагааны үндэс суурийг бий болгон ажиллаж байна. Бид Монгол хүн бүр өөрийн бүтээлцэж байгаа баялгийнхаа эзэн байх ёстой гэдэг үндсэн итгэл үнэмшлээ даган Хөрөнгө Оруулагч Үндэстэн санаачлагыг эхлүүлсэн бөгөөд энэ нь бидний шинэ маркетингийн брэнд болно.

Бид 2015 онд Үнэт Цаасны Төлбөр Тооцоо, Төвлөрсөн Хадгаламжийн Төв (ҮЦТТХТ)-д бүртгэлтэй Хаалттай хувьцаат компани болж өөрийн хуулийн статусаа өөрчилж чадлаа. ҮЦТТХТ-д амжилттай бүртгүүлснээр бид Монголын Хөрөнгийн Бирж (МХБ) дээр нээлттэй арилждаг анхны санхүүгийн компани

болоход нэг алхмын зайнд дөхөн очлоо. Манай хувьцаа эзэмшигчдийн тоо өнгөрсөн 5 жилийн туршид бууран 300-аас доош орсон бол 2015 оны сүүлчээр эргэн өсч, он дуусах мөчид эргээд 600 руу очив. Мөн Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоотой (ХБСХДХ) нягт хамтран ажиллаж, Ард Кредит ББСБ-аар дамжуулан, бөөний зээлийг амжилттай гаргаж, гишүүн байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллаж байна.

2015 он эдийн засгийн хямралтай, хүндхэн жил байсан хэдий ч бидний стратегийн хөрөнгө оруулалттай компани болох Ард Кредитын хувьд чамлахааргүй үр дүнтэй ажилласан жил болон өнгөрлөө. Компанийн ТУЗ болон менежментийн багийн хичээнгүй хөдөлмөрийн үр дүнд нийт хөрөнгийн хэмжээ 37 хувь өсч 4.6 тэрбум төгрөгт хүрэн 410 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан үр дүнтэйгээр 2015 оныг үдлээ.

Ард Кредит нь компанийн засаглал, ил тод байдал, нийгмийн хариуцлагын хувьд салбартаа тэргүүлэгч байгууллага болж цойлон гарч ирж байна. Бид 3 дахь жилдээ дараалан олон улсын нэр хүндтэй аудитын компани BDO Аудитаар санхүүгийн тайландаа шалгалт хийлгэлээ. Ард Санхүүгийн Нэгдэл өөрийн эзэмшлийн хувиа 50-иас 58 хувь хүртэл өсгөснөөр компанийн нийт гаргасан хувьцааны хяналтын багцыг эзэмших болсон билээ. Цаашид бид компанийг аль болох богино хугацаанд өсгөн томруулах бодлого баримтлах бөгөөд орчин үеийн технологи дээр суурилсан Монголын анхны Fintech компани болгох зорилготойгоор ажиллаж байна.



Чулуун ГАНЗОРИГ
Гүйцэтгэх захирал

Гүйцэтгэх захирлын МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагсад, харилцагч та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

2015 он бидний хувьд Ард Санхүүгийн Нэгдэлийн хөрөнгө оруулалттай компани болон өөрчлөгдсөнөөс хойш 2 дахь жилдээ бүтэн ажилласан онцлогтой жил байсан бөгөөд та бүхэнд жилийн тайлангаа толилуулж байгаадаа баяртай байна.

Дэлхийн эдийн засгийн байдал болон дотоод хүчин зүйлүүдээс шалтгаалан Монгол улсын эдийн засгийн өсөлт 2014 онд 7.8 хувь байсан бол 2015 онд 2.3 хувь болон буурч, нийт экспортын хэмжээ 4.5 хувиар уруудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувиас бага хэмжээнд очсон байна. Эдийн засгийн уналт нь банк санхүүгийн салбарт шууд нөлөө үзүүлж байгаа бөгөөд банкуудын нийт зээлийн багцын хэмжээ өмнөх оноос 6.5 хувиар буурч 11.7 тэрбум төгрөгт хүрч, чанаргүй зээлийн багц өмнөх оноос 2.1 нэгж хувиар өсч 7.1 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Хэдийгээр өнгөрсөн жил эдийн засгийн байдал таагүй байсан боловч бид компанийн өсөлт болон ашигт ажиллагааг ханган ажиллахын зэрэгцээ компанийн засаглал, хүний нөөц, гадаад харилцаа, бүтээгдэхүүн үйлчилгээгээ хөгжүүлэх тал дээр тодорхой ажлуудыг хийж, зах зээл дээрх компанийн байр сууриа бэхжүүлж ажиллалаа. Компанийн нийт хөрөнгийн хэмжээ 37 хувь өсч 4.6 тэрбум, цэвэр зээлийн багцын хэмжээ 38 хувь өсч 3.6 тэрбум төгрөгт тус тус хүрсэн бөгөөд

410 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан үр дүнтэйгээр 2015 оныг үдлээ. Түүнчлэн тайлант хугацаанд бид нийт 7.6 тэрбум төгрөгийн зээлийг 632 удаагийн олголтоор олгосон бөгөөд үүнээс 377 сая төгрөгийг хөдөө орон нутгийн 374 иргэдэд ХЗХ-оор дамжуулан олгосон дүнтэй байна.

2015 онд бид хувьцаа эзэмшигчиддээ 2014 оны ашгаасаа 100 сая төгрөгийн ноогдол ашиг хуваарилсан билээ. Мөн манай хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт орсон бөгөөд хамгийн том хувьцаа эзэмшигч болох Ард Санхүүгийн Нэгдэл, хувьцаа эзэмшигч Ч.Ганзоригос компанийн нийт гаргасан хувьцааны 8 хувийг худалдан авч 58 хувьтай болсон юм. Энэхүү арилжааг хийхдээ хувьцааны үнэлгээг бүртгэлийн үнийг 2 дахин үржүүлсэн үнээр тооцон авсныг цохон тэмдэглэе.

2016 онд эдийн засаг, зах зээлийн ерөнхий байдал сайжрах төлөвгүй байгаа бөгөөд бид компанийн үйл ажиллагааны зардал болон эрсдэлийг аль болох бага хэмжээнд барин ажиллахын зэрэгцээ зах зээл дээр шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх замаар компанийн төлөвлөгөөт өсөлтийг ханган ажиллахыг зорьж байна. Энэхүү эдийн засгийн хямрал нь компанийн хувьд анхны томоохон сорилт болж байна. Энэ үеийг ашиглан компанийн хүний нөөц, бүтэц, засаглал, эрсдэлийн удирдлага зэрэг цаашид өсөх үндсэн суурийг бэхжүүлж ажиллах шаардлагатай байгаа билээ. Ингэснээр бид хямралаас илүү хүчтэй болон гарч ирэх бөгөөд эдийн засаг эргээд өсч эхлэх үед бэлэн байх болно.



КОМПАНИЙН ТУХАЙ

Ард Кредит ББСБ ХХК нь 2011 оны 4-р сард үүсгэн байгуулагдан Монгол улсад бичил болон жижиг зээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэлийн хөрөнгө оруулалттай үндэсний компани юм. Бидний үйл ажиллагааны үндсэн чиглэл нь орчин үеийн дэвшилтэт аргачлалыг ашиглан бичил болон жижиг зээлийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх юм.

2011



2011 оны 4 дүгээр сард Интергруп Интернэшнл ХХК-ийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан.

2013



2013 онд шинэ хөрөнгө оруулалт хийгдэж компанийн үйл ажиллагаа идэвхижиж шинэ багаар, шинэ төлөвлөгөөтэй ажиллаж эхэлсэн.

2013 оны 12 дугаар сард компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт орж Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн шууд хөрөнгө оруулалттай компани болон өөрчлөгдсөн.

2013 оноос эхлэн ХБСХДХ-той хамтран ажиллаж эхэлсэн.

2014



2014 оны 2 дугаар сард анхны Хаалттай өрийн бичгээ гаргасан.

2014 оны 4 дүгээр сард Итгэлцлийн үйчилгээний тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагааны чиглэлээ өргөжүүлсэн.

2014 оны 9 дүгээр сард Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан (БСХС)-тай хамтран ажиллаж эхэлсэн.

2015



2015 оны 5 дугаар сард Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орсон.

2015 оны 7 дугаар сард Зээлийн өргөдлийг цахим хэлбэрээр хүлээн авдаг болсон.

2015 оны 9 дүгээр сараас эхлэн Техник Технологийн Дээд сургуультай хамтран ажиллаж эхэлсэн.

2015 оны 12 дугаар сард Оны Шилдэг Нийгмийн Хариуцлага Хэрэгжүүлэгч Байгууллага болсон.

Хувьцаа ЭЗЭМШИГЧИД



Ард Кредит нь нийт 4 хувьцаа эзэмшигчтэй бөгөөд хамгийн том хувьцаа эзэмшигч болох Ард Санхүүгийн Нэгдэл нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар өөрийн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм.

Төлөөлөн удирдах ЗӨВЛӨЛ

Компанийн ТУЗ нь нийт 6 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд үүнээс 1 гишүүн хараат бусаар ажиллаж байна. Ард Кредит нь олон улсын жишигт нийцэхүйц компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэн Монгол улсын банк бус санхүүгийн салбарт жишиг байгууллага болон ажиллаж байна.



Чулуун ГАНХУЯГ
Гүйцэтгэх захирал
Ард Санхүүгийн Нэгдэл



Сэдбазар ГЭРЭЛТУЯА
Гүйцэтгэх захирал
Мон Интернэшнл ХХК



Чулуун ГАНЗОРИГ
Гүйцэтгэх захирал
Ард Кредит ББСБ



Нэмэхбаатар ЭРДЭМБАЯР
Гүйцэтгэх захирал
Зар ХХК



Барамсай ГАНБАТ
Гүйцэтгэх захирал
Техник Технологийн Дээд Сургууль



Ванданцэрэн БАЯРЖАРГАЛ
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал
ИнтерГрупп ХХК

Бүтэц, зохион БАЙГУУЛАЛТ



Хүний НӨӨЦ

Бидний хувьд ажиллагсад нь компанийн хамгийн чухал үнэт зүйл бөгөөд бид байгууллагаараа бахархдаг, байгууллагын ирээдүйг тодорхойлогч, чадварлаг, байгууллагын хөгжлийг даган өөрсдийгөө хөгжүүлдэг, сэтгэл ханамжтай баг хамт олныг бүрдүүлж ажиллахыг зорьж ирсэн билээ.

Энэ жилд гүйцэтгэх захирал, үйл ажиллагаа эрхэлсэн захирал, маркетингийн мэргэжилтэн, 3 зээлийн мэргэжилтэн, нягтлан бодогч, жолооч гэсэн орон тоогоор, жирэмсэн болон амаржсны чөлөөтэй 3 ажилтан, нийт 11 үндсэн ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулсан байна.

2015 онд ажиллагсаддаа Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо (МББСБХ)-аас зохион байгуулагдсан зээл, нягтлан бодох бүртгэл, засаглал, удирдлагын чиглэлээр 5 удаагийн сургалтанд хамруулж, бизнес төлөвлөгөө боловсруулах, зээлийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх зорилготой 2 удаагийн дотоод сургалт зохион байгуулсан байна. Дээрх сургалтуудад нийт ажиллагсад 63 хувь нь хамрагдаж мэргэжлийн ур чадвараа дээшлүүлээ.



Бүтээгдэхүүн ҮЙЛЧИЛГЭЭ

Ард Кредит нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7-р зүйлд заасан ББСБ-ын эрхлэхийг зөвшөөрсөн 10 төрлийн үйл ажиллагаанаас дараах 4 төрлийн үйл ажиллагааг эрхэлж байна.

Үүнд:

- Зээл
- Гадаад валютын арилжаа
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөгөө өгөх
- Итгэлцлийн үйлчилгээ

Бидний үйл ажиллагааны үндсэн чиглэл нь орчин үеийн дэвшилтэт аргачлалыг ашиглан Монгол улсын иргэдэд бичил болон жижиг зээлийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх юм.


2015 оноос эхлэн харилцагчиддаа хурдан шуурхай, чирэгдэл багатай үйлчилгээ үзүүлэх зорилгоор онлайн зээлийн өргөдөл бөглөх системийг нэвтрүүлсэн билээ. Оны эцсийн байдлаар онлайнаар нийт 51 зээлийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Бид 2015 онд шинээр өрхийн зээл, сургалтын төлбөрийн зээл, итгэлцэл барьцаат зээл, ажиллагсдын зээл зэрэг шинэ зээлийн бүтээгдэхүүнүүдийг гарган нийт 9 төрлийн зээлийн бүтээгдэхүүнээр харилцагчдаа үйлчилж байна.

Үүнд:

- Төслийн зээл
- Бичил бизнесийн зээл
- Жижиг дунд бизнесийн зээл
- Хоршоо хөгжил зээл
- Өрхийн зээл
- Цалингийн зээл
- Ажиллагсдын зээл
- Шуурхай зээл
- Итгэлцэл барьцаат зээл

Итгэлцлийн ҮЙЛЧИЛГЭЭ



Ард Кредит нь 2014 оны 4 дугаар сард Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд харилцагчиддаа өндөр өгөөж бүхий санхүүгийн бүтээгдэхүүнийг санал болгон ажиллаж байна. 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт 855.5 сая төгрөгийн итгэлцэл татаж амжилттай санхүүжилт төвлөрүүлэн ажилласан байна.


Бид хөрөнгө итгэмжлэгчийн хүсэлтээр шинээр зээлийн үйлчилгээ нэвтрүүлэн итгэмжилсэн хөрөнгийг барьцаалж зээл олгож эхэлсэн. Мөн итгэлцлийн үйлчилгээгээ сайжруулан хугацаанаас хамааруулан хүүгийн хувь хэмжээг ялгавартай тогтоож өглөө.

Хөдөө орон НУТАГ

Бид хөдөө орон нутгийн иргэдэд хүрэн
ажилахын тулд ХБСХДХ-той 2013
оноос хойш хамтран ажилласан бөгөөд
тус холбооны гишүүн **61** ХЗХ-доор
дамжуулан зээл олголт хийж байна.

2015 онд бид нийт 19 хоршооны
374 гишүүдэд нийт **377** сая
төгрөгийн санхүүжилтийг олгосон
байна.

Зээлийн багцын чанарын хувьд манай
хамгийн эрсдэлгүй багц болон хөгжөөд
байна.





Хасбаян Өлзийт ХЗХ

Хасбаян Өлзийт ХЗХ нь 2006 онд 44 гишүүнтэйгээр санхүүгийн үйлчилгээг орон нутагт хүртээмжтэй хүргэх, гишүүн бүрийн бизнес харилцааг дэмжих, сум орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

Хасбаян Өлзийт ХЗХ нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн ХБСХДХ-ны гишүүн байгууллагаар идэвхитэй ажиллаж, 2014 оны 04 дүгээр сараас Ард Кредит ББСБ-тай хамтын ажиллагааг эхлүүлсэн. Манай хоршоо нь

нийт 3 удаа дамжуулан олгох санхүүжилт авснаар нийт актив 314.4 сая төгрөг, 255 гүшүүнтэй болж, санхүүжилт авахаас өмнөх үетэй харьцуулбал нийт актив 2.3 дахин, гишүүдийн тоо 30 хувиар тус тус өссөн байна. Бидний үйл ажиллагааг дэмжин уян хатан нөхцөлтэй зээлийн үйлчилгээ үзүүлж улмаар хөдөө орон нутагт санхүүгийн үйлчилгээ авах боломжоор хязгаарлагдмал иргэдэд санхүүгийн үйлчилгээгээ хүргэж ажилладагт нь Ард Кредит ББСБ-ын хамт олондоо талархаж явдагаа илэрхийлэхэд таатай байна.

ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Засаглал

- ТУЗ болон түүний хороодыг нийт 5 удаа хуралдуулж компанийн засаглал, тайлагнал, ил тод байдлыг улам сайжруулан ажилласан.
- Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж Ард Санхүүгийн Нэгдэлийн 58 хувь эзэмших болсон.

Санхүүжилт

- Олон улсын бичил санхүүгийн сангуудтай холбоо тогтоож, танилцуулгууд хийж ажилласан.
- ХХБ-наас 250 сая төгрөгийн шугаман зээл авсан.
- БСХС-гаас 500 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан.

Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

- Боловсролыг дэмжих, оюутан залуусыг тогтвортой суралцах боломжийг олгох үүднээс сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүн гаргасан.
- Зээлийн өргөдлийг цахим хэлбэрээр хүлээн авдаг болсон.
- Цахим хуудсаараа дамжуулан харилцагчиддаа зориулж 24 цагийн Онлайн туслах үйлчилгээг нэвтрүүлсэн.

Шагнал Урамшуулал

- Үйл ажиллагаа эрхэлсэн захирал Д. Сэлэнгэ нь Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооноос “Санхүү Банкны Тэргүүний Ажилтан” цол тэмдэгээр шагнагдсан байна.

АРД КРЕДИТ НЬ “ОНЫ ШИЛДЭГ
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА”-ААР
ӨРГӨМЖЛӨГДӨВ.

Нийгмийн ХАРИУЦЛАГА



Монголын Эндүро Мотоспортын
холбоо



Монголын Эндүро Кроссын аварга тамирчин
П.Мөрөн



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн
тусгай 29 дүгээр сургууль



Хүндийн өргөлтийн паралимпийн тамирчин
Э.Содномпилжээ



Дуулиан 2020



Хөдөөгийн Бичил Санхүүгийн
Хөгжлийг Дэмжих Холбоо







САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлант хугацаанд компанийн нийт хөрөнгийн хэмжээ 37 хувь өсч 4.6 тэрбум, цэвэр зээлийн багцын хэмжээ 38 хувь өсч 3.6 тэрбум төгрөгт тус тус хүрсэн бөгөөд 410 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай

ажиллалаа. Бид нийт 7.6 тэрбум төгрөгийн зээлийг 632 удаагийн олголтоор олгосон бөгөөд үүнээс 380 сая төгрөгийг хөдөө орон нутгийн 374 иргэдэд ХЗХ-оор дамжуулан олгосон дүнтэй байна.

Гол ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Зээлийн багцын мэдээ

	2015	2014	%
Олгосон зээлийн дүн (мянган төгрөг)	7,635,065	5,853,658	30%
Олгосон зээлийн тоо	632	427	48%
Нийт идэвхтэй зээлийн багц (мянган төгрөг)	3,706,114	2,677,649	38%
Нийт идэвхтэй зээлийн тоо	438	305	44%
Нэг зээлийн дундаж үлдэгдэл (мянган төгрөг)	8,461	8,779	-4%
Чанаргүй зээл (хувь)	5	3	67%

Ард Кредит нь 2015 онд 632 иргэн, аж ахуйн нэгжид 7.6 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өмнөх оны олголтоос 30 хувиар өссөн байна. 2015 оны жилийн эцсээр идэвхтэй зээлийн багц 3.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 38 хувиар өсгөлөө.

Бүтээгдэхүүний төрлөөр

2015 оны эцэст нийт бичил бизнесийн зээлийн үлдэгдэл 668,3 сая төгрөг, нийт идэвхтэй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь 18 болж өмнөх оноос 3 хувиар өссөн байна.



Өрхийн орлогоор



2015 онд амжиргааны доод түвшингөөс доогуур орлоготой 135 иргэдэд зээл олгосноор бид Монгол улсын ядуурлыг бууруулахад багахан хэмжээний хувь нэмэрээ оруулсан байна.

Зээл олгосон хэмжээгээр

2015 онд нийт олгосон зээлийн 47 хувь нь бичил зээл зээлж байгаа нь өмнөх оноос 12 хувь өссөн байна.



Байршилаар



Бид алслагдсан хөдөө орон нутагт бичил санхүүгийн үйлчилгээг хүргэх зорилго тавин ажилласнаар нийт олгосон зээлийн 19 хувийг хөдөө орон нутгийн иргэдэд хүргэж, өмнөх оноос 11 хувиар өссөн байна.


An abstract painting featuring a central face-like shape in dark, almost black tones, set against a vibrant, textured background of reds, oranges, and yellows. The face has stylized, elongated features and is surrounded by intricate, cross-hatched patterns. The overall composition is dynamic and expressive, with visible brushstrokes and a rich, layered texture.

ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр эдийн засгийн бодит өсөлт 2.3 хувьтай гарсан бөгөөд уул уурхайн салбар 13 хувь, хөдөө аж ахуй 10.7 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 5.7 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 2.9 хувиар өссөн нь голчлон нөлөөлжээ. Харин бөөний болон жижиглэн худалдаа 3.6 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 21.1 хувь, барилга 1.4 хувиар буурсан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн байна.

Эдийн засгийн ОРЧИН


ДНБ-ий өсөлт %



Салбаруудын өсөлт (%)

	2014	2015
Бодит ДНБ	7.9	2.3
Хөдөө аж ахуй	13.7	10.7
Уул уурхай, олборлолт	19.4	13.0
Боловсруулах үйлдвэрлэл	4.2	1.3
Цахилгаан хий, уур, агааржуулалт	5.3	2.7
Барилга	-4.3	-1.4
Бөөн/жижиглэнгийн худалдаа	2.4	-3.6
Тээвэр	14.8	5.7
Мэдээлэл, холбоо	4.7	2.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	10.2	2.9
Бүтээгдэхүүний цэвэр татвар	-8.1	-21.1

Инфляцийн түвшин %




Гадаад худалдааны тэнцэл (сая төгрөг)




■ Нийт эргэлт ■ Экспорт ■ Импорт ■ Тэнцэл

Ажилгүйдлийн түвшин %



Монгол улсын төсвийн тэнцэл (сая төгрөг)





ББСБ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

2015 онд нийт 450 ББСБ тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулсан байна. ББСБ-уудын нийт актив өмнөх оны мөн үеэс 22.7 хувиар өсч 623 тэрбум төгрөг хүрч банкны нийт актитын 3 хувьтай тэнцэж байгаа бөгөөд энэхүү өсөлтөд эзэмшигчдийн өмчийн дүн 110.1 тэрбум төгрөгөөр буюу 33.2 хувиар, үүний дотор хувь нийлүүлсэн хөрөнгө 50.2 тэрбум төгрөгөөр буюу 19.5 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

ББСБ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

2015 оны 12 сарын 31-ны байдлаар



ББСБ-ын тоо **450**
Улаанбаатарт 400 /88.8%/
Хөдөө орон нутагт 50 /11.1%/



Нийт актив **623.2**
Банкны салбарт 3.01%
тэрбум



Нийт зээлийн багц **391.2**
Банкны салбарт 3.4%
тэрбум



Нийт дүрмийн сан **308.4**
Банкны салбарт 46.6%
тэрбум



Нийт эзэмшигчдийн өмч **424.2**
Банкны салбарт 16.78%
тэрбум



Зээлийн дундаж хүү **3.8%**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо
↑ Өмнөх оны мөн үетэй харьцуулсан өсөлт

Хүчтэй. Хамтдаа.





Утас: +976 77404041
Факс: +976 77451150
www.bdo.mn

“БДО Аудит” ХХК
АБ Центр, 10-р давхар
Их сургуулийн гудамж 31./1
Сүхбаатар дүүрэг, 6-р хороо
Улаанбаатар Монгол улс
14193

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“АРД КРЕДИТ ББСБ” ХХК -ийн хувь нийлүүлэгчдэд

Санхүүгийн тайлангийн талаар

Бид “Ард Кредит ББСБ” ХХК-ийн (цаашид “ББСБ” гэх) 6-44 дүгээр хуудсанд тусгагдсан 2015 оны 12-р сарын 31-ний өдрийн Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон жилийн Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан болон Мөнгөн гүйлгээний тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу бэлтгэж, шударгаар толилуулах үүрэгтэй. Үүнд санхүүгийн тайлангуудыг алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэж, шударгаар толилуулахуйц дотоод хяналтыг зохиож, ажиллуулан, хэвийн түвшинд сахих; тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, хэрэглэх; нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийх үүрэг хариуцлага багтдаг.

Аудиторын хүлээх хариуцлага

Бид гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах үүрэгтэй. Бид аудитаа Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооноос гаргасан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, ёс зүйн шаардлагуудыг баримтлан гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажил нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын үндэслэлийг тестийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багтаадаг. Санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдэлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцоолууд, хэрэглэсэн бүртгэлийн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг.

Бидний хийсэн аудитын ажил нь эдгээр санхүүгийн тайланд дүгнэлт гаргах хангалттай үндэслэл болж чадна гэж үзлээ.

Аудиторын дүгнэлт

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд, “Ард Кредит ББСБ” ХХК-ийн 2015 оны 12-р сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн байна.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох “Ард Кредит ББСБ” ХХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Огноо: 2016.03.24

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

	2015 он мян.төг	2014 он мян.төг
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	667,194	502,570
Харилцагчдад олгосон зээл	3,733,138	2,658,162
Үндсэн хөрөнгө	126,144	197,816
Биет бус хөрөнгө	4,003	4,000
Бусад хөрөнгө	120,997	25,707
НИЙТ ХӨРӨНГӨ	4,651,476	3,388,255
Богино хугацаат зээлийн эх үүсвэр	1,687,082	760,059
Өрийн бичиг		250,000
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	845,537	500,828
Бусад өр төлбөр	94,804	47,665
Урт хугацаат зээлийн эх үүсвэр	132,350	248,864
Нийт өр төлбөр	2,759,773	1,807,416
Дүрмийн сан	1,000,000	1,000,000
Нэмж төлөгдсөн капитал	100,000	100,000
Хуримтлагдсан ашиг	791,703	480,839
Нийт өөрийн хөрөнгө	1,891,703	1,580,839
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	4,651,476	3,388,255

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

	2015 он мян.төг	2014 он мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	1,234,028	889,298
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(290,199)	(210,295)
Хүүгийн цэвэр орлого	943,829	679,003
Хураамж ба шимтгэлийн орлого	50,394	47,920
Цэвэр валют арилжааны олз/гарз	(360)	(3,029)
Хүүгийн бус цэвэр орлого	50,034	44,891
Ажиллагсадтай холбогдолтой зардал	(236,705)	(157,053)
Үйл ажиллагааны зардал	(235,965)	(148,753)
Эрсдлийн нөөцийн зардал	(71,666)	(57,791)
Үйл ажиллагааны ашиг	449,527	360,297
Үйл ажиллагааны бус бусад олз/гарз	8,865	(22,184)
Татварын өмнөх цэвэр ашиг	458,392	338,113
Орлогын албан татвар	(47,528)	(38,082)
Татварын дараах цэвэр ашиг	410,864	300,031
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр)	41	30

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

	Хувьцаат капитал мян.төг	Хуримтлагдсан ашиг мян.төг	Нэмж төлөгдсөн капитал мян.төг	Нийт мян.төг
2014 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,000,000	180,808	100,000	1,280,808
Гаргасан хувьцаа				-
2014 оны 12 сарын 31-ний тайлант хугацааны цэвэр ашиг		300,031		300,031
Нэмж төлөгдсөн капитал				-
2014 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,000,000	480,839	100,000	1,580,839
Төлсөн ногдол ашиг		(100,000)		(100,000)
Тайлант хугацааны цэвэр ашиг		410,864		410,864
2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,000,000	791,703	100,000	1,891,703

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2015 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

	2015 он мян.төг	2014 он мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг /(алдагдал)	458,393	338,113
Тохируулга:		
Элэгдэл хорогдлын зардал	24,061	15,801
Зээлийн эрсдэлийн сангийн зардал	66,304	57,791
Авлагын эрсдэлийн сангийн зардал	2,266	
Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	3,096	
Өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулсны олз	(3,342)	
Хүүгийн орлого	(1,234,028)	(889,298)
Хүүгийн зардал	290,199	210,295
Үйл ажиллагааны актив, пассивын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	(393,051)	(267,298)
Зээлийн (өсөлт)/бууралт	(938,760)	(1,037,819)
Бусад активын (өсөлт)/бууралт	(95,651)	(21,961)
Итгэлцлийн өглөгийн өсөлт/(бууралт)	344,709	500,828
Өрийн бичгийн өсөлт/(бууралт)	(250,000)	250,000
Бусад пассивын (бууралт)/ өсөлт	(518)	11,928
Үйл ажиллагааны актив, пассивын өөрчлөлт	(940,220)	(297,025)
Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгө	(1,333,271)	(27,321)
Төлсөн орлогын албан татвар	(43,431)	
Хүлээн авсан хүү	1,127,217	869,305
Төлсөн хүү	(246,640)	(199,107)
Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон цэвэр мөнгөн гүйлгээ	(496,125)	78,555
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Худалдан авсан өмч, барилга, тоног төхөөрөмж	(43,660)	(195,763)
Худалдан авсан биет бус хөрөнгө	(1,100)	(300)
Оруулсан хөрөнгө оруулалт	(5,000)	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(49,760)	(196,063)
САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Банк, бусад санхүүгийн байгууллагаас авсан зээл	1,597,350	529,233
"Банк, бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эргэн төлөлт"	(786,841)	(52,860)
Төлсөн ногдол ашиг	(100,000)	
Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	710,509	476,373
Тайлант жилд бий болсон нийт цэвэр мөнгөн гүйлгээ	164,624	358,865
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлсийн оны эхний үлдэгдэл	502,570	143,704
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлсийн оны эцсийн үлдэгдэл	667,194	502,570

Хамтран ажилладаг байгууллагууд



Ард Санхүүгийн Нэгдэл буюу Ард Холдингс нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй манлай компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар өөрийн хувь нийлүүлэгчдийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм.



Ард Даатгал нь 1994 онд байгуулагдсан анхны хувийн даатгалын компани бөгөөд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд болон бүх аймагт 25 салбар, 370 гаруй төлөөлөгчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж буй зах зээлд тэргүүлэгч даатгалын компани юм.



Ард Секюритиз ҮЦК нь 1997 онд байгуулагдан Монгол улсын Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын банкны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй зах зээлд тэргүүлэгч ууган компаниудын нэг юм.



Ард Актив ХЗХ нь 2004 онд үүсгэн байгуулагдсан ба 2013 онд бүтэц удирдлагын хувьд шинэчлэгдэн тэтгэврийн урт хугацаат хадгаламжийн үйлчилгээг дагнан эрхэлж буй, банк санхүүгийн салбарт арвин туршлагатай баг хамт олноос бүрдсэн хоршоо юм.



Тэнгэр системс нь 2007 онд програм хангамж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэйгөөр байгуулагдаж, Монголын програм хангамжийн компаниудын анхдагч нэгэн компани юм.



Вайлд Дижитал нь 2013 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд салбартаа тэргүүлэгч залуу хамт олноос бүрдсэн орчин үеийн хэрэгцээ шаардлагын дагуу мэдээллийн технологи дээр суурилсан маркетингийн цогц шийдэл, бүтээлч дизайн болон вэб дизайны шинэлэг санаа бүхий цогц үйлчилгээг харилцагчиддаа санал болгон ажиллаж байгаа эрч хүчтэй залуу компани юм.



Санхүүгийн Зохицуулах Хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм.



Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан нь иргэдийн амьжиргааны эх үүсвэрийг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад бөөний зээл олгохоос гадна бичил санхүүгийн салбарын хөгжлийг дэмжих, салбарын чадавхийг бэхжүүлэх, хөдөө орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор шаталсан сургалтуудыг зохион байгуулдаг санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ гэсэн 2 үндсэн үйл ажиллагааны чиглэл баримтлан ажилладаг Сан юм.



Дуулиан 2020 нь Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн ивээл дор хөл бөмбөгийн тэмцээн 10 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдсан. Тэмцээний үндсэн зорилго нь найрсаг улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд хөлбөмбөгийн хөгжилд хувь нэмрээ оруулах, хүүхэд багачуудын эрүүл мэндэд туслалцаа үзүүлэх, материалаг бааз, тоглох нөхцөл бололцоог бий болгох, байгууллагуудтай хамтран ажиллаж тэдний нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.



Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбоо нь 2003 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг хадгаламж зээлийн хоршоодыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн гишүүдээ үйлчилдэг, ашгийн бус төрийн бус байгууллага юм.

An abstract painting by Erdenebayar Munkhbayar. The background is a vibrant, textured red. Overlaid on this are several dark, almost black, geometric shapes that resemble architectural frames or windows. A prominent vertical rectangular frame in the upper center contains a bright yellow and orange abstract form. Other similar, though less distinct, frames are visible in the lower half of the composition. The overall effect is one of dynamic contrast and layered depth.

Монхорын Эрдэнэбаяр (зураач)

Эрдэнэбаяр 1968 онд Баруун-Урт хотод төрсөн ба 1987 онд Дүрслэх Урлагийн Сургуулийг төгссөн бөгөөд тэрээр өнөөдрийн Монголын орчин үеийн урлагийн томоохон төлөөлөгчдийн нэг юм. Тэр Буддын соёлын нөлөө болон уламжлалт Монгол сэтгэлгээг барууны орчин үеийн урлагтай хослуулсан онцлогтой уран бүтээлч юм. Эрдэнэбаярын үзэсгэлэнгүүд болох Тал Нутгийг Хамгаалагч, Талын Оюун Санаа, Хар Морь, Салхийг Хамгаалагч, Монголын Улаан Морь, Улаан Морины Аялал, Азийн Чоно гэх мэтчилэн үзэсгэлэнгүүдийн нэрсээс харвал түүний бүтээлийн ерөнхий утга санааг ойлгож болно. Эрдэнэбаяр эдгээр үзэсгэлэнгүүдээрээ гадаадад Монголын дүрслэх урлагийг таниулж, Тайландын TeoNamfah Галлерейд, Сингапурын Artrium MICA Building-д болон Luxe Museum-д, Энэтхэгийн Мумбай хотын Studio Napean Gallery-д, Хонг Конгийн Schoeni Art Gallery-д, Швейцарын Distellerie Gallery-д тус тус бие даасан үзэсгэлэнгүүдээ гаргасан.

Жилийн тайланд маань өөрийн уран бүтээлээс тавихыг зөвшөөрсөн зураач М.Эрдэнэбаяртаа Ард Кредит ББСБ-ын хамт олны өмнөөс талархлаа илэрхийлж, цаашдын уран бүтээлд нь өндөр амжилт хүсэж байна.

ARD КРЕДИТ
ББСБ

и-мэйл: info@ardcredit.com
вебсайт: www.ardcredit.com
утас: +976 7700 3322